



ТӨВСҮМБЭР АИМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 02 өдөр

Дугаар А/13

БАЯНТАЛ СУМ

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Булгачин овогтой Цагаан Батхуяг нь 1 дүгээр баг Их-Уул 1-104 тоот хаягт гэр бүлийн хэрэгцээний зориулалтай 0 0192га (192 метр квадрат) газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Борхигон овогтой Батмөнх Хонгорзул-д (РД: ЕЙ85112202)-д шилжүүлж 11 жилийн хугацаатайгаар тус эзэмшүүлсүгэй.

2. Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч Б.Хонгорзул-д үүрэг болгосугай.

3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу авч (Б.Хонгорзул)-д газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2018 оны А/19 дүгээр захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА  Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АИМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 02 өдөр

дугаар А/74

Баянтал сум

Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх
шийдвэрт эерчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43.1, "Монгол улсын иргэнд газар өмчлүүлэх тухай хууль"-ийн 7 дугаар зүйлийн 7.1, 14 дүгээр зүйлийн 14.1.1, 21 дүгээр зүйлийн 21.1, 21.2 дах заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын Засаг даргын "Газар өмчлүүлэх тухай" 2008 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 32 дугаар захирамжийн 4 дүгээр хавсралтын 74 дүгээрт бүртгэгдсэн гэр бүлийн хамтын хэрэгцээнний зориулалтаар өмчилсөн иргэн Намжилдорж овогтой Мөнхжаргал (РД: ЕЙ87112009)-г шинэчилсэн хаягаар Баянтал сумын 1 дүгээр баг Сүлд-7 дугаар гудамжны 733 тоот хаягт 0.4996 га /4996м.кв/ газрын шийдвэрт эерчлөлт оруулсугай.
2. Өмчилж авсан газраа үл хөдлөх хөрөнгийн бүртгэлд бүртгүүлэх, өмчийн газраа бусдын өмчлөлд шилжүүлэх, эзэмшүүлэх, ашиглуулах тохиолдолд эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авч байхыг газар өмчлөгч иргэнд үүрэг болгосугай.
3. Захирамжийн биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.



ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АИМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 05 өдөр

Шуудан А/75

Баянтал сум

Ажлын хэсэг томилох тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.1, Захиргааны ерөнхий хууль 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан "Төсвийн хөрөнгө оруулалтын санхүүжих журам"-ын 4.13 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


Сумын төвийн 1 дүгээр худгийн засварын ажлыг техникийн тодорхойлолт болон барааны тоо хэмжээнд заагдсан шаардлагын дагуу хүлээж авах ажлын хэсгийн дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Ажлын хэсгийн дарга:	Э.Эрхэмбаатар (Засаг даргын орлогч дарга)
Гишүүд :	Э.Түмэн-Эрдэнэ (1-р багийн Засаг дарга)
	Н.Сарантуяа (Аж ахуйн нярав)
	Б.Наранцэцэг (Жижүүр)
Нарийн бичгийн дарга:	М.Бодьгэрэл (Худалдан авах ажиллагааны мэргэжилтэн)

2. 1 дүгээр худгийг хууль журмын дагуу хүлээж авахыг ажлын хэсгийн дарга, гишүүдэд үүрэг болгосугай.

3. Уг ажлыг чанартай зохион байгуулж тайлагнахыг ажлын хэсгийн нарийн бичгийн дарга /М.Бодьгэрэл/-д даалгасугай.

ДАРГА  Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АИМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 08 өдөр

Дугаар А/76

БАЯНТАЛ СУМ

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол улсын Засаг захиргаан, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 59 дүгээр зүйлийн 59.1.4 Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.2.8, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2022 оны 06 дугаар сарын 29-ны өдрийн 05 дугаар тогтоолын 3 дугаар хавсралтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. “Малын тоо толгойн албан татвар”-ын орлогыг “Бэлчээрийн менежментийг сайжруулах, бэлчээрийн болон газар тариалангийн усан хангамжийг нэмэгдүүлэх, малын эрүүл мэндийг хамгаалах, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, малын чанарыг сайжруулах, гэмт халдлага, гамшгаар хамгаалах, малын тэжээлийн ургамал тариалах, тэжээлийн нөөц бүрдүүлэх, байгаль орчныг хамгаалах, хортон мэрэгчидтэй тэмцэх” ажлуудын төлөвлөгөөний дагуу зохион байгуулахыг Худалдан авах ажиллагаа хариуцсан мөргөжилтөн (М.Бодьгэрэл)-д даалгасугай
2. Дээрх үйл ажиллагаанд шаардагдах төсөв хөрөнгийг Орон нутгийн хөгжлийн сангийн зардлаас тус тус зарцуулсугай.
3. Уг зардлын задаргааг нэгдүгээр хэлсрэлтээр баталсугай.
4. Хэрэгжилтэд хяналт тавьж үр дүнг 2022 оны 11 дугаар сарын 20-ны дотор танилцуулахыг санхүү албаны дарга (Л.Отгонлүрэн)-д даалгасугай.
5. Энэ захирамж гарсантай холбогдуулан Засаг даргын 2022 оны 03 дугаар сарын 22-ны А/19 дугаар захирамжийн хүчингүй тооцсугай



ДАРГА

ГАНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/77

Баянтал сум

Газар эзэмших эрх шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 29.2, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Газрын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.1, 27.2, 38 дугаар зүйлийн 38.4 дахь заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Иргэн Боржгин овогтой Цэрэннадмид Доржбат нь 2 дугаар баг 596-р точкын зүүн талд, засмалын баруун талд худалдаа, үйлчилгээний зориулалтай 0.02га (200 метр квадрат) газрын газар эзэмших эрхийг шилжүүлэх хүсэлт гаргасан тул иргэн Монгол овогтой Түмэн Базархүү-д (РД: ЗГ80042719)-д шилжүүлж 6 жилийн хугацаатайгаар эзэмшүүлсүгэй.
2. Хуулийн дагуу ашиглаж буй газрынхаа орчны тохижилтыг сайжруулж, зүй зохистой ашиглахыг газар эзэмшигч (Т.Базархүү)-д үүрэг болгосугай.
3. Газар эзэмших эрхийг хуулийн дагуу авч (Т.Базархүү)-д газар эзэмших гэрээ байгуулж, гэрчилгээ олгон хууль тогтоомжийн дагуу хяналт тавьж ажиллахыг Газрын даамал (Ц.Загарсүрэн)-д үүрэг болгосугай.
4. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2014 оны А/106 дугаар захирамжийн 10 дахь хэсгийг хүчингүй болсонд тооцсугай.

ДАРГА

Г.АНХБАЯР



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
БАЯНТАЛ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2022 оны 09 сарын 29 өдөр

Дугаар А/78

Баянтал сум

Орон тооны бус комисс
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66.1 дүгээр зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46.1, Засгийн газрын 2019 оны 08 дугаар сарын 14-ны өдрийн 325 дугаар тогтоол “Гудамж, зам талбай үл хөдлөх эд хөрөнгийг хаягжуулах журам”-ын 2.1 дэх заалтуудыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Хот, суурин газрын гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах үүрэг бүхий орон тооны бус комиссыг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсгай.

Комиссын дарга:

Сумын Засаг даргын орлогч

Нарийн бичгийн дарга:

Газрын даамал

Гишүүдэд:

Засаг даргын Тамгын газрын дарга

Санхүү албаны дарга

1 дүгээр багийн Засаг дарга

2 дугаар багийн Засаг дарга


1 дүгээр БИНХ-ын дарга

2 дугаар БИНХ-ын дарга

Төрийн бус байгууллагын төлөөлөл

2. Хот, суурин газрын гудамж, талбайд нэр өгөх, өөрчлөх, нэрэмжит болгох санал боловсруулах ажлыг тухай бүрт зохион байгуулж, ажиллахыг орон тооны бус комиссын даргад үүрэг болгосугай.

3. Энэ захирамж гарсантай холбогдуулан сумын Засаг даргын 2016 оны А/07 дугаар захирамжийг хүчингүй болсонд тооцсугай.



ДАРГА

Г.АНХБАЯР